# 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТУХАЙ ТАЙЛАН

2020.06.25

Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгт хандан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын “Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67-р тогтоолыг мөрдлөг шийдвэрлэж, иргэдэээс амаар, бичгээр, нээлттэй утас 7059106, 70593951 утсаар болон цахим хэлбэрээр хүлээн авч, шийдвэрлэлтийн явцыг тухай бүр мэдээлэн ажиллаж байна.

2020 оны эхний хагас жилд иргэдээс нийт 127 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 125 гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэлээ. Шийдвэрлэх хугацаа болоогүй буюу судлагдаж, хянагдах шатандаа явагдаж буй 2 өргөдөл байна.

**Эрүүл мэндийн газар:**

2020 оны эхний хагас жилийн байдлаар бичгээр ирсэн 9, Засгийн газрын 11-11 төвд гаргасан гомдол ба шилжиж ирсэн 1, 70593951 утсанд ирсэн 7 нийт 17 гомдол, хүсэлтийг хүлээн авч судлан шийдвэрлэж хариу тайлбар хүргүүлэн, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. 2019 оноос хойш байгууллагын дэргэд иргэдийн өргөдөл, гомдол хүлээж авах нээлттэй 70593951 утсыг ажиллуулж эхэлсэн ба эмч, эмнэлгийн ажилчид, иргэд мэддэг болсон байна.

**Нэгдсэн эмнэлэг:**

2020 оны эхний хагас жилийн байдлаар иргэдээс ирсэн нийт 110 өргөдөл, гомдлыг хүлээн авч, “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн дагуу 108 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг иргэнд хүргүүлсэн. Нийт өргөдөл, гомдлын 19 буюу 17,2% нь иргэдээс, 91 буюу 82,8% нь ажилчдаас байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдол эзлэж байна. 2 өргөдөл, гомдол судлагдах шатандаа, шийдвэрлэх хугацаа дуусаагүй байна.

**Өргөдөл, гомдлын дагуу авч, хэрэгжүүлсэн арга хэмжээ:**

- Ажилчдаас гаргасан хөдөлмөрийн харилцаатай холбоотой 60 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажлын зохицуулалт хийж 1-5 хүртэлх хоногийн чөлөөг олголоо.
- Ажилд орохыг хүссэн 27 иргэний өргөдлийг хүлээн авч, ажлын байранд тавигдах шаардлага хангасан 5 хүнийг ажилд авч, нарийн мэргэжлийн 1 эмчийг хүний нөөцийн бүртгэлд бүртгэж авлаа.

- Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтанд хамрагдах, суралцахыг хүссэн 5 эмнэлгийн тусгай мэргэжилтэнтэй /сувилагч 3, лаборант 1, ЭТТ-ийн техникч 1/ гэрээ хийж төрөлжүүлсэн мэргэжлийн сургалтанд хамрууллаа.
- Тасгийн эрхлэгчээс чөлөөлөгдөхийг хүссэн 1 их эмчийг төрөх тасгийн эрхлэгчээс чөлөөлж, эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх эмчээр үргэлжлүүлэн ажиллуулахаар шийдвэрлэлээ.
- Эмнэлгийн ажилтны харилцаа хандлагын талаар ирүүлсэн 1 гомдлыг Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх ёс зүйн хэсгийн хороогоор судлуулж, сувилахуйн албанд шилжүүллээ.
- Хүүхэд асрах чөлөө хүссэн 3 ажилтанд журмын дагуу Нэгдсэн эмнэлгийн даргын тушаалаар чөлөөг олголоо.
- Эмчилгээ үйлчилгээтэй холбоотой Засгийн газрын 11-11 төв, Эрүүл мэндийн газрын нээлттэй 70593951 утсаар өгсөн 8 өргөдлийг судлаж шийдвэрлэлээ. Үүнд: холбогдох өргөдөл гомдлын дагуу дотрын эмчийн үзлэгийн өрөөнд зохион байгуулалт хийж, шүдний ломбоны уусмалын хангалтыг ханган нийлүүлэх байгууллагын үйл ажиллагааны алдаа байсныг мэдэгдэж, кабинетийн үйлчилгээний ачааллын талаар үйлчлүүлэгчид мэдээлэл өгч, амбулаториор үйлчлүүлж байгаа иргэдэд улавч зарахыг зогсоож, нурууны зураг авхуулахаар рентген харалт хийлгэсэн дүнэлтийг амбулаторийн картанд бичиж өгч шийдвэрлэсэн.

**Шийдвэрлэсэн байдал:**

2020 оны эхний хагас жилийн байдлаар Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэгт иргэд, ажилчдаас гаргасан нийт 127 өргөдөл, гомдол, санал хүсэлт хүлээн авч, хуулийн хугацаанд 100% шийдвэрлэж хариуг эзэд нь хүргүүлж ажиллалаа.

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЭМГ-ЫН УТСХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН С.ӨЛЗИЙБАЯР

ХЯНАСАН:

ЭМГ-ЫН НЭМХ-ИЙН ДАРГА Б.САРУУЛЦЭЦЭГ

Хүснэгт 1

## 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2020.06.25

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо | Шийдвэрлэлт | | | | Шийдвэрлэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн | Хугацаа болоогүй | |
| 1 | Эрүүл мэндийн газар | 17 | 17 | 0 | 0 | 0 | 100% |
| 2 | Нэгдсэн эмнэлэг | 110 | 108 | 0 | 0 | 2 | 100% |
| | **НИЙТ ДҮН** | **127** | **125** | **0** | **0** | **2** | **100%** |

Хүснэгт 2

## 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ \ХЭЛБЭРЭЭР\

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл гомдол санал хүсэлт | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Бичгээр | Цахим хэлбэрээр | Утсаар хандсан | Биечлэн уулзсан | Бусад |
| 1 | Эрүүл мэндийн газар | 17 | 9 | 0 | 8 | 0 | |
| 2 | Нэгдсэн эмнэлэг | 19 | 17 | 1 | 1 | 0 | |
| | **НИЙТ ДҮН** | **36** | **26** | **1** | **9** | **0** | |

Хүснэгт 3

## ӨРГӨДӨЛ ГОМДОЛ САНАЛ ХҮСЭЛТИЙН АГУУЛГА \ХУВИАР\

| № | Байгууллагын нэр | Зонхилж байгаа асуудал \тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь\ | | |
|---|---|---|---|---|
| 1 | **Дундговь аймаг** | Өргөдөл | 127 | |
| | | Хүсэлт | 106 | |
| | | Санал | - | |
| | | Гомдол | 21 | |
| | | Талархал | | |
| | | **Асуудлын нэр** | **Нийт тоо** | **Нийт хувь** |
| | | Хөдөлмөрийн зохион байгуулалт хийлгэж чөлөө хүссэн | 60 | 47,3% |
| | | Ажилд орохыг хүссэн | 27 | 21,2% |
| | | Мэргэшин суралцах хүсэлтэй | 7 | 5,5% |
| | | Эмчилгээ,үйлчилгээний чанар,хүртээмжтэй холбоотой | 5 | 3,9% |
| | | Ажлаас чөлөөлөгдөхийг хүссэн | 4 | 3,1% |
| | | Тасгийн эрхлэгчээс чөлөөлөгдөхийг хүссэн | 2 | 1,5% |
| | | Үр дүнгийн урамшуулал олгохыг хүссэн | 1 | 0,7% |
| | | ЭМХ-д заасан тэтгэмжинд хамруулахыг хүссэн | 5 | 3,9% |
| | | Хүүхдээ харах эхийн чөлөө хүссэн | 3 | 2,3% |
| | | Нэмэгдэл хөлс олгохыг хүссэн | 2 | 1,5% |
| | | Тэтгэмж хүссэн | 1 | 0,7% |
| | | Тэтгэвэрт гарахыг хүссэн | 1 | 0,7% |
| | | Цалингийн шатлалын асуудлыг шийдвэрлүүлэхийг хүссэн | 1 | 0,7% |
| | | Түр орлон гүйцэтгэсний цалин урамшуулал олгохыг хүссэн | 2 | 1,5% |
| | | Талархал | 1 | 0,7% |
| | | Ёс зүй харилцаа хандлагатай холбоотой | 2 | 1,5% |
| | | Ажил хавсарны хувь авах хүсэлт гаргасан | 1 | 0,7% |
| | | Ажлын байрны тодорхойлолтод хүүхдийн асуудал оруулах хүсэлт | 1 | 0,7% |
| | | | 1 | 0,7% |